

“АЗ ЖАРГАЛТАЙ ИРГЭН “ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2018.06.12.

<i>№</i>	<i>Зорилт</i>	<i>Зохион байгуулах арга хэмжээ</i>	<i>Шалгуур үзүүлэлт</i>	<i>Хэрэгжилт</i>	<i>Хувь</i>
Удирдлага зохион байгуулалт					
1.		1.1.Ажлын хэсгийн хурлыг хийнэ.	Тухай бүр хурлыг хийж гишүүдэд үүрэг өгч,зохион байгуулсан ажлын үр дүнг хэлэлцэнэ.	Ажлын хэсгийг хурлыг 4 удаа хийж,ажлын явц,үр дүнгийн талаар 8 асуудал хэлэлцлээ.	100
		1.2.Хөтөлбөрт хамрагдах иргэдийн судалгааг гаргана.	Баг бүр судалгаа хийж хөтөлбөрт хамрагдах иргэдээ сонгоно.	Баг бүрээс өрхийн амьжиргааны судалгаагаар өрхийн баталгаажих түвшин доогуур үнэлэгдсэн өрхүүдээс хөтөлбөрт хамрагдах 75 өрхийг сонгож, дэлгэрэнгүй нарийвчилсан судалгаа авч судалгааны дүнгээр 55 өрхийг сонголоо.	100
		1.3.Судалгааг засаг даргын зөвлөлд танилцуулна.	Судалгааны бодит байдал таницуулагдсан байна.	Сонгогдсон 51 өрхийн 244 иргэний дэлгэрэнгүй судалгааг гаргалаа. Насанд хүрэгчид-104, хүүхэд-140, өрх толгойлсон эх-18, эцэг-1, ХБИргэн-5, оюутан-4, ЕБС-ийн сурагч-80, СӨБ-35, 0-1 настай хүүхэд-25 байна.	100
		1.4.Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.	Нээлтэнд сонгогдсон өрхийн иргэд бүрэн хамрагдсан байна.	Нээлтийн үйл ажиллагаанд сонгогдсон 46 өрхийн иргэд оролцож, хөтөлбөрийн зорилго, хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцлаа.	100
		1.5.Ажлын хэсгийн гишүүнийг сургалтанд хамруулна.	Туршлага судлах сургалтанд 1-3 хоног хамрагдсан байна.	Хугацаа болоогүй	-
		1.6. Ажлын явцын ХШҮнэлгээ хийж, аялал зохион байгуулна.	Ажлын явцын үнэлгээ гарсан байна.	Ажлын явцыг багийн нийгмийн ажилтан бүрээс ажлын тайлангаар үнэллээ. Эхний хагас жилд хийх хэрэгжүүлэх ажлаа 93.0 % тай гүйцэтгэлээ.	100
Нэг.Эрүүл мэндийн тусламж шаардлагатай гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, эрүүлжүүлэх					
2	Зорилт -1	1.1.1.Эрүүл мэндийн үзлэгт хамруулан зөвлөгөө мэдээллийг өгнө	Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлийг илрүүлэх үзлэгт өрхийн гишүүд 100 хувь хамрагдана.	Хөтөлбөрт хамрагдсан 46 өрхийн насанд хүрсэн 86 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. Үзлэгээр даралт, өндөр, жингийн илүүдэл, хөхний үзлэгт үзэж зөв хооллолтын талаар мэдээлэл өглөө. 1 иргэн хөхний өвчтэй байсныг илрүүлж,дараагийн шатны шинжилгээ өгч эмчилгээнд орлоо.	100

		1.1.2.Гэр бүлийн өвчлөлтэй гишүүдэд нарийн мэргэжлийн эрүүл мэндийн үзлэг оношлогоо зохион байгуулна.	Иргэдийг оношлогоонд хамруулна.	“Эрүүл цус” аяны хүрээнд шинжилгээнд 24 иргэн, хөхний хавдрын илрүүлэг үзлэгт 10, эмэгтэйчүүдийн паб шинжилгээнд 3 ээж, 4 иргэн эсийн шинжилгээнд хамрагдлаа. Нийт 41 иргэнийг шинжилгээ, оношлогоонд хамрууллаа. Бусад 45 иргэнд үзлэгээр өөрчлөлт илрээгүй байна	100
		1.1.3. Архины хамрааралтай иргэдийг архинаас татгалзах сургалт, эмчилгээнд хамруулна.	Хорт зуршлын хэрэглээтэй 15 өрхийн гишүүн архи тамхинаас татгалзах эмчилгээнд хамрагдана.	Архины хамааралтай 3 өрхийн 3 иргэнийг “Говийн хийморь” АА-төвийн сургалтанд 2 удаа хамруулж одоогийн байдлаар 1, өөрөө сайн дураараа 1 иргэн хорт зуршлаас гарч, нийтийг хамарсан ажил хийж байна.	70
		1.1.4.Гэр бүлийн гишүүдийг харилцааны сургалтанд хамруулна.	Гэр бүлийн гишүүд харилцааны эерэг аргад суралцсан байна	Нийт 8 төрлийн сургалт зохион байгууллаа. Үүнд: ➢ Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга - 72 ➢ Гэр бүлийн үнэ цэнэ сургалтанд - 72 ➢ Аавуудын сургалт – 23 ➢ Ээжүүдийн сургалт – 48 ➢ Аюулгүйн 10 дүрэм – 15д авхардсан тоогоор 230 иргэн хамрагдлаа. Сургалтаар дамжуулан хүүхдээ хэрхэн зөв хүн болгох, цаашид эцэг эх бид юу дээр анхаарах шаардлагатай гэр бүлийн үнэ цэнэ юун дээр тогтдог талаарх мэдлэг олголоо.	100
Хоёр.Хөдөлмөр эрхлэлт ,нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх,мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн чадамж олгох сургалтанд гэр бүлийн гишүүдийг хамруулах, иргэнийг ажлын байранд зуучлах					
2	Зорилт -2	2.2.1.Иргэдийн сургалтын хэрэгцээг тодорхойлно.	Сургалтын захиалга авсан байна.	Нийт 12 чиглэлээр 45иргэнээс сургалтын захиалга авлаа.Үүнд: Касс нярав худалдагчийн сургалт-10, нэхмэлийн сургалт-12 ,оёдлын – 8,туузан урлал -1, засварчин-1 ,Үсчины -1 ,мужаан-4, гагнуур-1, маникюр-1,тогооч-1 ,үйллэгч худалдагч 3,авто чиглэлээр 2 байна. Захиалгын дагуу ХХҮГазартай хамтран ажиллаж байна.	100
2.2.2.Хөдөлмөрт бэлтгэх тогоочийн болон бусад сургалтанд саналын дагуу хамруулна.		Оролцох иргэдийн тоо	Эхний хагас жилд 6 иргэний хүсэлтийн дагуу кас,с нярав, худалдагчийн сертификат олгох сургалтанд - 5, нэхмэлийн сургалтанд-11 иргэнийг хамрууллаа.	100	
2.2.3. Ажилгүй иргэдийн бүртгэлд иргэдийг бүртгүүлнэ.		Ажил идэвхтэй хайгч иргэнээр 100% бүртгүүлнэ.	Ажилгүй 77 иргэний 65 иргэн ХХҮГазарт ажил идэвхитэй ажил хайгч иргэнээр бүртгүүллээ.	70	

		2.2.4.Сонгогдсон өрхийн насанд хүрсэн гишүүд байнгын болон түр ажлын байранд зуучлагдана.	Сонгогдсон өрхийн 60 дээш хувь нь ажлын байранд зуучлагдсэн байна.	Хагас жилийн байдлаар байнгын ажилд-15, түр ажлын байранд -18, нийт-33 иргэнийг ажилд зуучиллаа.	100
		2.2.5.Орон нутагт хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг илрүүлнэ.	Баг бүрээр судалгаа гаргасан байна.	Сонгогдсон 51 өрхийн 0-18 насны 140 хүүхдийн судалгааг гаргахад хөдөлмөр эрхэлж буй хүүхэд байхгүй байна.	100
		2.2.6. Өөрсдийн чадварт түшиглэн бизнес эрхлэхэд нь дэмжинэ	Сум хөгжлийн сангийн болон бусад зээл тусламжинд хамруулна.	Өрхийн амжиргааг дэмжих эргэн төлөгдөх 3 сая төгрөгний төсөлд 2 , 1 сая төгрөгний буцалтгүй дэмжлэгт 3 , нийт – 5 иргэнийг зээлэнд хамрууллаа.	70
		2.2.7. “Гэр үнэлгээ”-ний маягтын дагуу өрхүүдийн амьдралын нөхцөл байдалд үнэлгээ хийнэ.	Судалгааны дагуу шаардлагатай өрхийг нийгмийн халамжийн дэмжлэгт хамруулна.	Сонгогдсон 51 өрхөөр явж, ахуй амьдралтай нь танилцаж нөхцөл байдлын үнэлгээ хийлээ. Үнэлгээгээр тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай-4 , хяналтанд байх шаардлагатай-2 , хэвийн- 45 өрх байна. Одоогийн байдлаар 1 өрхийг ӨАТТСудалгаанд хамруулж, 3 өрхөд ДЗОНХХ-тэй хамтран гар угаалтуур өгч, 10 хүүхдэд хувцасны дэмжлэг үзүүллээ.Одоогоор нийгмийн халамжийн дэмжлэг авсан 18 өрх байна.	100
Гурав. Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх					
3	Зорилт-3	3.3.1.Өрхийн тэргүүн аавуудын дунд гэр бүлийн харилцааны хандлага өөрчлөх сургалт явуулна.	Иргэдийн захиргааны хэргийн зөрчил гарган түр саатуулагдах явдал багассан байна	Аавуудын сургалтанд 23 аавыг хамрууллаа. Сургалтаар аавуудын харилцааны хандлага өөрчлөгдөж, архины хор уршиг гэр бүл, үр хүүхдэд хэрхэн нөлөөлдөг гэр бүлийн халуун дулаан уур амьсгал хичнээн чухал болохыг таниулж,ярилцлага хийлээ. Энэ сургалтаас хойш хөтөлбөрт хамрагдсан аавууд ямар нэгэн хэрэг зөрчил гаргаагүй болно .	100
		3.3.2.“Миний хайртай аав” үйл ажиллагаа зохион байгуулна.	Өрхийн бүх аавууд хамрагдаж,үйл ажиллагаанд оролцсон байна.	Хугацаа болоогүй	-
		3.3.3.Гэр бүлийн тухай хууль гэр бүлийн хүчирхийллийн тухай болон зөрчлийн тухай хуулийг сурталчилан таниулна.	Захиргааны хэргийн зөрчил болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн удаа дараа дуудлага өгсөн өрхийн гишүүдийг сургалтанд албадан хамруулсан байх	Сонгогдсон 51 өрхийн дунд ямар нэгэн гэмт хэрэг зөрчил илрээгүй байна. Багийн нийгмийн ажилтнууд судалгааны дагуу хяналт тавьж байна.	100
Дөрөв.Гэр бүлийн өмнө нэн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд эрх зүйн болон нийгмийн үйлчилгээний тусламж үзүүлэх					

4	Зорилт-4	4.4.1.Зан төлвийн судалгаа хийнэ.	Эрсдэлийг асуулт анкетын аргаар авна. Хүүхдийн тусламж 108 утасны програмд орсон эсэхэд хяналт тавина.	Хүүхдийн тусламжийн утас 108-д 1 өрхийн 2 хүүхдийн талаар мэдээлэл ирсэний дагуу гэр айлчлал хийж, эрсдлийн үнэлгээ гаргаж, кейс нээн ажлын төлөвлөгөө гаргалаа. Ажлын хэсэг 7 хоногт 1 удаа гэр эргүүлийг хийлээ.	100
		4.4.2. Зан үйлд нөлөөлөх арга хэмжээ, сургалтуудыг зохион байгуулах	-Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх шаардлагатай өрх гэр бүлийн талаар судалгаа гаргасан байна. -Гэр бүлийн хурал, чин сэтгэлийн ярилцлагуудыг сар бүр зохион байгуулах -Гэр бүлийн гишүүдийн харилцаа нээлттэй болсон байна. .	Сургалтыг дараах сэдвээр явууллаа. Гэр бүлийн үнэ цэнэ, хүүхэд хүмүүжийн эерэг арга, 9-11 насныханд хүүхдийн аюулгүйн 10 дүрэм, Гэр бүлийн тухай хууль гэр бүлийн хүчирхийллийн тухай болон Зөрчлийн тухай хууль, Хүний эрхийн тухай ойлголт, Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг тогтоох зорилгоор фокус бүлгийн ярилцлагыг давхардсан тоогоор нийт 269 иргэнд сурталчиллаа. Үүний үр дүнд гэр бүлийн зан хандлага өөрчлөгдөж эерэг хандлагатай болж,зарим гэр бүлийн гишүүдийн хүүхэдтэйгээ харьцах, эхнэр нөрхийн харьцаа нээлтэй болж, ажлын хэсгээс зохион байгуулц байгаа үйл ажиллагааны оролцоо нь нэмэгдлээ. Хүүхдийн баярыг тохиолдуулан өрхийн ээж, аавуудын дунд гэр бүлийн хүчирхийллийн шалтгааныг тогтоох хэсэгчилсэн ярилцлагыг зохион байгуулж, 71 иргэн хамрагдлаа. Дараа нь хөтөлбөрийн өрхийн 140 хүүхдэд засаг дарга гарын бэлэг өглөө.	100
		4.4.3.Сонгогдсон өрхийн хүүхдүүдийг дугуйланд хамруулан авьяасыг нээн хөгжүүлнэ.	Хүүхдийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн дугуйланд хүүхдийг 100% хамруулна.	Судалгаагаар өөрийн сонирхлын дагуу 21 хүүхэд дугуйланд хамрагддаг. Хамрагдах хүсэлтэй 26 хүүхэд байгаагаас жүжгийн дугуйланд-1, шатар даам-3, дууны дуйланд-10, сагс- 1, бөхийн дугуйланд-1, зургийн дугуйланд – 2 байна. Одоогоор ТТХ-ийн театрт 1 хүүхдийг дууны дугуйланд хамрууллаа.	70
		4.4.5. Шаардлагатай гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх шаардлагатай өрх гэр бүлийн талаар судалгаа гаргасан байна	Төвийн 5 багийн нийгмийн ажилтнууд хөтөлбөрт хамрагдсан иргэдийн санаа бодлыг сонсож тэдэнд өөрийн боломжоор зөвлөгөө өгч ажиллаж байна. Зөвлөгөө өгөх шаардлагатай 1 өрхийн 2 иргэнийг тодорхойлж ГБХЗХГ-ын улсын хүүхдийн байцаагчтай хамтран уулзалт ярилцлага зохион байгууллаа.	100
Тав.Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх					

5	Зорилт-5	5.5.1. Сонгогдсон өрхийн хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулна.	Сургууль,цэцэрлэгийн бүртгэлийн тоогоор	Хөтөлбөрт хамрагдсан 140 – хүүхдээс ЕБС-ийн сурагч-80, цэцэрлэгт -35, эхийн асрамжинд 0-1,9 настай хүүхэд-25 байна .	100
		5.5.2.Бичиг үсгийн боловсролгүй иргэдэд анхан шатны сургалтыг зохион байгуулна.	Гэр бүлийн бичиг үсэггүй гишүүдийн судалгааг гарган, сургалтанд хамруулна.	Судалгаагаар бичиг үсэггүй 2 иргэн байна. 1 иргэн нь хөгжлийн бэрхшээлтэй, сургалтанд хамрагдах боломжгүй.	70
Зургаа. Иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, бичиг баримтын зөрчлийн асуудлуудыг шийдвэрлэнэ.					
6	Зорилт-6	6.6.1. Нийгмийн даатгалын тухай хуулийн өөрчлөлт шинэчлэлт ашиг тус, ач холбогдлын талаар мэдээ мэдээллийг хийнэ.	Иргэдийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын төлөлтийн судалгааг гаргана.	Хөтөлбөрт хамрагдсан насанд хүрэгчид нийт 104 иргэн байгаагаас 1 иргэн тэтгэвэрт гарсан байна. Сайн дурын нийгмийн даатгал төлдөг - 20, төлдөггүй - 83 иргэн байна. ЭМДаатгал төлдөг- 65 , төлдөггүй -38 иргэн байна. Үүнээс: НДШ төлдөг нь 19,4%, төлдөггүй нь 80,5%, ЭМДаатгал төлдөг нь 63,1%, төлдөггүй нь 36,8%-тай байна. Цаашид даатгалд хамрагдах иргэдийн тоо нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	70
Долоо.Нэн шаардлагатай өрхийг эзэмшлийн газартай болгох					
7	Зорилт-7	7.7.1.Сонгогдсон өрхийн гишүүд өмчлөлийн газрын гэрчилгээ авсан судалгааг гаргана.	Судалгаа гаргаж, өмчлөлийн газаргүй иргэдийн тоог гаргасан байна.	Хөтөлбөрт хамрагдсан нийт 244 иргэн байгаагаас өмчлөлийн газартай – 90, аймгийн ГХБХБГазарт материал бүрдүүлж өгөөд байгаа – 99, бусад нь өргөдөл гаргаагүй байна.	100

Хэрэгжилт: 93.0 %

Сайнцагаан сумын ЗДТГазар